



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 4/137

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.21 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн 3.1.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн
ТУШААХ нь:

1. “Эмэгтэйчүүдийн эмгэгийн үед хийгдэх мэс заслын заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү зааврыг хэрэгжүүлэхэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэхийг Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Буянтогтох), Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Энхтөр), Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөл (ерөнхий мэргэжилтэн Б.Цэдмаа)-д тус тус даалгасугай.

3. “Эмэгтэйчүүдийн эмгэгийн үед хийгдэх мэс заслын заавар”-ыг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээр судлуулах, нэн шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвтөө багтаан ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Ганцэцэг)-т даалгасугай.

САЙД



С. ЭНХБОЛД

141210673

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 03
сарын 17-ны өдрийн 1/37 дугаар
тушаалын хавсралт



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМГЭГИЙН ҮЕД ХИЙГДЭХ МЭС ЗАСЛЫН ЭМНЭЛЗҮЙН ЗААВАР

Нийтлэг үндэслэл

Энэхүү зааврын зорилго нь нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд тохиолдож буй эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны эмгэгийн үед эрүүл мэндэд тулгарч буй эрсдлийг эрт илрүүлэн тогтоож, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эмнэлзүйн нотолгоонд суурилсан эмнэлгийн тусламж, үйлчилгээг хугацаа алдалгүй үзүүлэхэд чиглэнэ.

Уг зааврыг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд, эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны эмгэгийн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хэрэгжүүлнэ.

Товчилсон үг:

- ЭХЭМҮТ – Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
- ЭБЭЭ – Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг
- ЭЭСТ – Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасаг
- ICD – Өвчний олон улсын ангилал

Өвчний олон улсын үйлдлийн ангилал (ICD-9-CM) (1)

- 65.4 – Нэг талын өндгөвч гуурсан хоолойг авах
- 65.5 – Хоёр талын өндгөвч гуурсан хоолойг авах
- 66.4 – Нэг талын гуурсан хоолойг бүрэн авах
- 66.5 – Хоёр талын гуурсан хоолойг бүрэн авах
- 68.3 – Хэвлийгээр умайн их биеийг тайрах
- 68.4 – Хэвлийгээр умайг бүрэн тайрч авах
- 68.41 – Хэвлийн хөндийн дурангаар умайг бүрэн тайрах
- 68.5 – Үтрээгээр умайг тайрах
- 68.51 – Хэвлийн хөндийн дурангийн тусламжтай үтрээгээр умайг тайрах

Мэс заслын заалт:

- I. Умайн хоргүй хавдар
- II. Умайн цус алдалтууд эмийн эмчилгээнд үр дүнгүй
- III. Умайн унжилт эмийн болон дасгал хөдөлгөөн, уламжлалт эмчилгээний аргуудад үр дүнгүй
- IV. Эндометриозын хүнд хэлбэр эмийн эмчилгээнд үр дүнгүй байгаа цэвэршилтийн өмнөх ба цэвэршилтийн насны эмэгтэйчүүдэд
- V. Аденомиозын хүнд хэлбэр эмийн эмчилгээ үр дүнгүй
- VI. Бага аарцгийн эрхтний идээт үрэвсэлт өвчин эмийн эмчилгээнд үр дүнгүй байгаа, цэвэршилт орчмын ба цэвэршилтийн дараах насны эмэгтэйчүүд
- VII. Аарцгийн архаг өвдөлтийн улмаас эмийн эмчилгээ үр дүнгүй байгаа цэвэршилт орчмын ба цэвэршилтийн дараах насны эмэгтэйчүүд
- VIII. Умайг цэвэрлэх болон бусад ажилбаруудын хүндрэлийн улмаас умайг авах шаардлага үүссэн үед
- IX. Эх барихын болон эмэгтэйчүүдийн гаралтай үжил халдвараас шалтгаалж умайг авах нөхцөл үүссэн үед
- X. Эмэгтэйчүүдийн байрлалтай хортой хавдар, түүний урьдал эмгэгүүд:
 - a. Умайн хүзүүний өмөн, түүний урьдал эмгэгүүд
 - b. Умайн салстын болон их биеийн өмөн, түүний урьдал эмгэгүүд
 - c. Өндгөвчийн өмөн, түүний урьдал эмгэгүүд
 - d. Трофобластын эмгэгүүд.
 - e. Трофобластын хавдар

Мэс заслын эсрэг заалт:

- 1) Ерөнхий мэдээ алдуулалт хийх боломжгүй
- 2) Гемодинамик тогтворгүй
- 3) Эмчилгээ хийгээгүй коагуляпати
- 4) Хүнд уушги зүрхний эмгэг
- 5) Биеийн жингийн индэкс 35-с их
- 6) Олон удаа хэвлийн нээлттэй мэс засалд орсон.
- 7) Бага аарцгийн их хэмжээний наалдацтай
- 8) Хүйс орчимд 50%-с дээш наалдацтай

Анхаарах зүйлс:

1. Хагалгаанаас өмнө эмнэлзүйн дэлгэрэнгүй оношийг баталгаажуулж тасгийн эрхлэгч эмч, ахлах жижүүр эмч танилцуулж баталгаажуулсан байна. Шаардлагатай бол зөвлөх эмч болон эмч нарын хамтарсан үзлэг хийж

баталгаажуулна. Төлөвлөгөөт хагалгааг эмчилгээ эрхэлсэн дэд захирал, эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч даргад танилцуулж баталгаажуулна.

2. Мэс заслаас өмнө хагалгааны бэлэн байдлыг хангасан байх, үйлчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд шаардлагатай мэдээллүүдийг өгч үйлчлүүлэгчээс зөвшөөрлийг заавал авч баримтжуулсан байна.
3. Мэс заслаас өмнө мэс заслын болон мэдээгүйжүүлгийн эмч нар зөвлөлдөж хагалгааны өмнөх ба дараах мэдээгүйжүүлэлт өвдөлт намдаалтын арга хэлбэрүүдийг сонгож тохирсон байна.

Мэс заслын өмнөх бэлтгэл

- Хагалгаа эхлэхээс 30-60 өмнө урьдчилан сэргийлэх тунгаар антибиотик тарих (Цефазолин 2 сая Ед-ийг судсаар хийх, харшилтай бол тохирсон антибиотикийг сорил тавьж хийх).
- Хэвлийн нээлттэй мэс засал хийх бол хэрэглэгдэх багаж тоног төхөөрөмж мэс заслын үед ямар нэгэн доголдол үүсгэхээргүй байхаар бэлтгэгдсэн байна.
- Дурангийн мэс засал хийх бол багаж тоног төхөөрөмж хэрэгслүүд (хүснэгт-1), мэдээгүйжүүлгийн багаж тоног төхөөрөмжүүдийн ажиллагаа нь цогц байдлаар хангагдсан, ажилбарын явцад ямар нэгэн доголдол үүсгэхээргүй байхаар бэлтгэгдсэн байна.
- Үйлчлүүлэгчид тохирсон мэдээгүйжүүлэг өгнө.
- Давсагт Фолейн катетр тавина.
- Антисептик уусмал, ариун материалаар хагалгааны талбайг ариутгана.
- Ариун материалаар мэс заслын талбайг тусгаарлана.

Хүснэгт №1 Дурангийн мэс заслын багаж

№	Багажны нэр	Тайлбар
1	0° эсвэл 30° лапароскопи	
2	Гармоник гар (Harmonic Scalpel or Ligasure Scalpel)	Тусгай генератор
3	Дахин ашиглагдах 2 туйлт гар (bipolar)	50W чадалтай
4	Торкар (5mm-3ширхэг, 10 эсвэл 12mm-1ширхэг)	
5	2 эрүүтэй граспер (duckbill grasper-2ширхэг)	
6	Умайн манипулятор (uterine manipulator)	

7	Хайч	
8	Угааж соруулах иж бүрдэл (suction irrigator)	
Нэмэлт шаардлагатай багаж		
9	Цахилгаан морцилатор (morcellator)	
10	Вазопрессин (Vasopressin)	10 нэгжээс илүү хэрэглэхгүй
11	Зүү	

Умайг авах мэс заслын хэлбэрүүд

- I. Хэвлийн нээлттэй мэс заслаар умайг авах
- II. Хэвлийн дурангаар умайг авах
- III. Үтрээний хүрцээр умайг авах

Хэвлийн хүрцээр умайг авах мэс заслын хэлбэрүүд:

- Умайг умайн хүзүүний дээгүүр тайрч авах (SAH-subtotal abdominal hysterectomy)
- Умайг умайн хүзүүний хамт бүхэлд нь тайрч авах (TAH-total abdominal hysterectomy)
 - Умайн их биеийг умайн хүзүүний хамт
 - Үтрээний дээд гуравны нэг хэсгээр авах
- Умайг авахдаа хоёр талын дайврын хамт авах
- Умайг хоёр талын үрийн хоолойн хамт, өндгөвчгүйгээр авах
- Умайг бүхэлд нь өргөтгөж авах (Wertheim, Radical Hysterectomy, Lymph node ectomy, internal ileac, external ileac, obturator commonly)

Хэвлийн нээлттэй мэс заслаар умайг бүхэлд нь авах

- I. Хэвлийг үечлэн цус тогтоолттой нээх
 - 1) Хэвлийн голын шугамаар умдаг хүйсний хооронд дагуу зүслэгээр
 - 2) Умдагны дээгүүр хөндлөн зүслэгээр (Пфаненштейл, Жоел-Кохен, Майлярд)
- II. Бага аарцгийг хангалттай харагдхуйц шархыг тэлэх, шарх тэлэгч байрлуулах. Гэдсийг самбайгаар тусгаарлана. Бүдүүн болон нарийн гэдэс, сэмж умайд наалдсан бол чөлөөлнө.
- III. Дайвруудын холбоосонд шулуун багаж тавьж умайг хөдөлгөхөд хялбар болгоно (дугуй холбоос, өндгөвч умайн холбоос, үрийн хоолойд Кохер (Kocher)-ын багаж тавина).
- IV. Дугуй холбоосыг 2 талд барьж боон чөлөөлж ретроперитониал зайг нээнэ.

- V. Умай өндгөвчний холбоосонд багаж тавьж чөлөөлөн цус тогтооно. Хэрэв өндгөвчийг хамтад нь авхаар шийдсэн бол аарцаг юүлүүрийн холбоосонд багаж тавьж салган боолт хийж цус тогтооно.
- VI. Давсгийг умайн доод сегмент болон умайн хүзүүнээс хуулж ялган салгаж чөлөөлнө. Умайн артерийн судасны багцад дотор хөөмийн буюу умайн доод сегментийн түвшинд тавьж хайчилж оёж бооно. Хажуу талаар нь 1.5 см зайтай шээлүүр байгааг анхаарах.
- VII. Умай-аарцгийн холбоосонд багаж тавьж, хайчилж оёж бооно.
- VIII. Умайн хүзүүний өргөн холбоосонд багаж тавьж салган оёж бооно. Энэ үед умайн хүзүү үтрээнээс зааглан ялгарна.
- IX. Умай хүзүүний доогуур, үтрээний дээгүүр хавчуураар барьж, тайрч авна. Үтрээний урд ба хойд ханыг Аллисийн хавчуураар барьж нэг булангаас нь эхлэн оёж битүүлнэ. Зарим тохиолдолд нээлттэй үлдээж болно (Хэрэв эх үрэвсэл халдвар ихтэй бол үтрээний амсарт цус тогтоох оёдол тавьж нээлттэй үлдээнэ).
- X. Цус тогтоолтыг хянаж багаж материалыг бүртгэн шарх тэлэгчийг авч хэвлийн урд ханыг үечлэн хаана.

Хэвлийн дурангаар умай авах хэлбэрүүд:

- 1) Хэвлийн дурангаар умайг умайн хүзүүний дээгүүр тайрах
- 2) Хэвлийн дурангаар умайг бүхэлд нь авах
- 3) Хэвлийн дурангийн тусламжтай үтрээний хүрцээр умайг бүхэлд нь авах

Хэвлийн дурангаар умайг авах мэс заслын техник:

- I. Үйлчлүүлэгчийг литотомийн байрлалд байрлуулна. Умайн манипулятор оруулна.
- II. Хэвлийд цоологч (торкар) оруулах
Хэвлийн хөндийд нэвтрэх үндсэн 2 арга байна.
 - 1) Хаалттай арга:

a. Вершийн зүү ашиглан хэвлийн хөндийг хийлэх (closed conventional trocar entry) – Пневмоперитониум үүсгэхдээ “Veress” зүүг ихэвчлэн хэвлийн гялтан хальс хэвлийн урд ханатай наалттай байдаг учир хүйсний дотор талд хатгана. Зарим тохиолдолд (хэвлийн урд ханаас хатгаж болохгүй үед) “Veress” зүүг арын хүнхрээгээр хатгаж болдог. Зүүг хэвлийн урд ханатай 45° өнцөг үүсгэж байхаар барьж хэвлийн урд ханыг дээш нь өргөж хатгана. Хэт тарган хүнд урт зүү хэрэглэнэ. Зүү хэвлийн хөндийд орсон эсэхийг сорилоор шалгана (Тариурын сорил: 10 граммын тариурт 5 г давсны уусмал соруулан зүүгээр шахахад уусмал төвөггүй орж байвал

зүү хэвлийн хөндийд байна гэж үзнэ). Хэвлийн хөндийд орсон бол нүүрс хүчлийн давхар ислээр 12-15кПа хүртэл хийлнэ. Хэвлийн хөндийг хийгээр хангалттай дүүргэсний дараа торкарыг их хүч хэрэглэхгүй, эргүүлэх хөдөлгөөнөөр өөрийнх нь хүчээр оруулна.

- b. Тэлэгч бүхий верешийн зүү хэрэглэн трокар оруулах (Radially expanding trocar entry)
- c. Шууд трокар оруулах (Direct sharp trocar entry)
- d. Оптик камерийн хяналтын дор трокар оруулах (optical trocar)

2) Нээлттэй арга: Хэвлийг нээж трокар оруулах (Hassan trocar entry)


Торкар оруулах: Торкарыг оруулахдаа дараах зүйлийг анхаарах шаардлагатай.

- Арьсны зүслэг хангалттай өргөн байх ёстой. Хэрэв арьсны зүслэг бага бол трокарыг оруулахад их хүч шаардагдаж гэнэт хүчтэй дарснаас гэдэс, сэмж, судас гэмтэх хүндрэл гарч болно.
- Торкарын голч, түүний гэр хоёр сайн тохирч байх ёстой.
- Торкарын үзүүр ир сайтай байх.

Дуран оруулах: Дуранг оруулахаас өмнө "White balance" үзэж фокусыг сайн тохируулна. Дараа нь дуранг оруулж хэвлийн хөндийд ерөнхий үзлэг хийнэ. Энэ нь хэвлийн хөндийг хийгээр MNS-4621:2008 дүүргэх болон цоологч оруулах үед үүсэж болох хүндрэлүүдийг эрт оношилоход тустай. Үүнийг үгүйсгэсний дараа бага аарцгийн хөндийн эрхтэнүүдийг шалгана. Бага аарцгийн эрхтэнийг шалгах үедээ үйлчлүүлэгчийг трендленбургийн байрлалд оруулна.

Туслах багаж оруулах: Эдгээр багажийн цоологчийг лапароскопийн шууд хяналтын доор оруулна. Гадна талаас "Spina iliaca anterior superior" дотор талаас a.umbilical obliterated хоёроор хатгах зайг тогтоож "Spina iliaca anterior superior"-оос 3 см зайд судасгүй газрыг тохируулан хатгаж, хажуугийн цоологчийг оруулна. Цоологч оруулах зүслэг 0.5 см байх ёстой (зураг-1).

Зураг №1 Дурангийн торкар оруулах байрлал



- III. Дугуй холбоосыг түлж таслах.
- IV. Өндгөвчийг авахаар шийдсэн бол аарцаг юүлүүрийн холбоосыг түлж таслах. Өндгөвчийг үлдээхээр шийдсэн бол үрийн хоолойг болон өндгөвчийн холбоос, өргөн холбоосуудыг ялгаж түлж хайчилж таслана.
- V. Умайн судсуудыг салгах.
Давсгийг чөлөөлөнө. Умайн артерийн судсыг биполяр түлэгчээр түлж таслан цус тогтоох шаардлага гарвал оёдол тавьж цус тогтоох.
- VI. Умай аарцгийн холбоосыг түлж таслах.
- VII. Умайн өргөн холбоосыг биполяр-аар түлж таслан үтрээний хана хүртэл буулган чөлөөлнө.
- VIII. Умайг гаргах.
Хэрвээ умайн хүзүүг үлдээхээр шийдсэн бол умайг умайн хүзүүний дээгүүр тайрч аваад цус тогтоох оёдолууд дурангийн тусламжтайгаар тавина. Умайг зориулалтын багажийн тусламжтай (morcellator-оор) хэвлийгээс гаргана.
Умайн хүзүүг авахаар шийдсэн бол үтрээг урд ханаар нь цоолж нээнэ. Умайн суурь холбоосуудыг түлж таслан цус тогтооно. Умайг чөлөөлж тойруулан хайчлан үтрээнээс салгаж, үтрээгээр гаргах ба багтахааргүй байвал зориулалтын багажаар жижиглэн гаргана.
- IX. Үлдэнгэрийг хаах.
 - a) Үтрээний хүрцээр түүний хана салстыг багажаар барьж үргэлжилсэн оёдол тавьж цус тогтооно.
 - b) Дурангийн тусламжтай оёдлын утсыг хэвлийд оруулан оёно.

X. Хэвлийн шархыг битүүлэх

Цус тогтоолтыг сайтар шалгана. Шаардлагатай бол шээлүүрийн гүрвэлзэх хөдөлгөөнийг шалгаж хянана. Багаж материалыг бүртгэн багажнуудыг гарган хэвлийн хийг гаргана. Хэвлийн шарханд зангилаат оёдол тавина.

Үтрээний хүрцээр умайг авах (VH-Vaginal hysterectomy)

- I. Умайг дайвруудын нь хамт бүхэлд нь авах
- II. Умайг дайваргүйгээр бүхэлд нь авч үтрээний ханыг нөхөн сэргээх
- III. Умайг үтрээний хүрцээр 2 хувааж дайваргүйгээр авах

Үтрээний хүрцээр умайг бүхэлд нь авах техник

1. Үтрээнд тусгай зориулалтын толь тавьж ариутгана. Умайн хүзүүнээс суман хавчуураар хавчиж татаж үтрээний хананд цагираг хэлбэрийн зүслэг хийнэ.
2. Умайн хүзүүнээс давсагыг чөлөөлнө. Өргөн холбоосонд багаж тавин хайчилж оёно.
3. Гялтанг ард болон урд талаас нээнэ.
4. Аарцаг- умайн холбоост хос багаж тавьж хайчилж оёно.
5. Умайн судасны багцанд хос багаж тавьж хайчилж оёно.
6. Умайн дугуй холбоост хос багаж тавьж хайчилж оёно. Өндгөвч авахгүй бол өндгөвчний холбоост хос багаж тавьж хайчилж оёно. Өндгөвч авахаар бол аарцаг юүлүүрийн холбоост хос багаж тавьж хайчилж оёно.
7. Умайг гадагшлуулна – хэмжээ том бол хэсэгчилж гаргана.
8. Гялтанг оёно.
9. Холбоосуудыг холбож зангидана (аарцаг-умайн холбоос, өргөн холбоос, өндгөвчний холбоосуудыг).
10. Үтрээний ханыг оёно.

Гарч болох эрсдэл, хүндрэл:

- Том судас гэмтэж цус алдах, гэдэс болон сэмж цоорох, давсаг, шээс дамжуулах суваг гэмтэх, гялтан болон арьсан доор хий хурах, давсаг үтрээний цорго үүсэх, хошног үтрээний цорго үүсэх, шарх халдварлагдах, өөөр шээсний замын халдвар.

Ном зүй

1. **WHO.** *ICD-9-CM.* 1986.
8. **WHO.** *ICD-10.* Geneva : s.n., 1986.
2. **M.E.Klingensmith, C.Vemuri, O.M.Fayanju, J.O.Robertson, P.P.Samson, D.E.Sanford.** *Вашингтон Мэс заслын гарын авлага.* Улаанбаатар : s.n., 2020. ISBN: 978-9919-23-259-7.
3. **H.W.Jones, J.A.Rock.** *TE LINDE'S OPERATIVE GYNECOLOGY (11TH EDITION).* s.l. : LWW, 2015. ISBN: 978-1-4511-7736-7.
4. **S.Berek, Jonathan.** *Berek and Novak's Gynecology (6th edition).* s.l. : LWW, 2020. ISBN: 978-1-4963-8033-3.
5. **M.S.Baggish, M.M.Karram.** *Atlas of Pelvic Anatomy and Gynecologic Surgery (4th edition).* s.l. : Elsevier, 2016. ISBN: 978-0-323-22552-6.
6. **Т.Эрхэмбаатар, Г.Санждорж.** *Эх барих эмэгтэйчүүдийн мэс засал.* Улаанбаатар : s.n.
7. **ЭМЯ.** *Түгээмэл үйлдлийн стандарт MNS 4621:2008.* Улаанбаатар : s.n., 2008.
9. **ЭМЯ.** *ЭМС-ын А/611 тоот тушаал.* Улаанбаатар : s.n., 2019.